НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 03 сарын 15 өдөр Дугаар 04 Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ,
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

"8.Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газраас дэвшүүлсэн "Цахим үндэстэн" болох зорилт, нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр цахим шигжилтийн хүрээнд, төрийн анхан шатны нэгжид ажиллаж буй хэсгийн ахлагчдын ачааллыг хөнгөвчлөх, хариуцлагыг нэмэгдүүлэх "Хэсгийн ахлагчийн систем" болон иргэдэд зориулсан гар утасны аппликейшны талаарх танилцуулгыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга О.Чинзориг танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1.Хэсгийн ахлагчийн систем болон иргэдэд зориулсан гар утасны аппликейшныг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэглээнд нэвтрүүлэхийг Нийслэлийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/1488 дугаар захирамжаар байгуулагдсан (Ажлын хэсэг)-т:

2."Хэсгийн ахлагчийн систем"-ийн үйл ажиллагааг одоо мөрдөгдөж буй "Хэсгийн ахлагч нарын ажиллах нийтлэг журам"-д нийцүүлж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт;

3."Хэсгийн ахлагчийн систем"-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж жигдрүүлж нутагшуулах ажлыг зохион байгуулах, хэсгийн ахлагч нарын гар утасны интернэтийн зардлыг санхүүжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга нарт;

4."Хэсгийн ахлагчийн систем"-ийн орчны зөрчил мэдээлэх хэсэгт бүртгэгдсэн зөрчлүүдийг харьяалагдах чиг үүргийн байгууллагад шилжүүлэх, шийдвэрлэлтийн индексийг тооцоолж, дүн шинжилгээ хийх, хяналт тавьж 14 хоног тутам нийслэлийн удирдлагуудад танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв (Б.Ууганбат)-д;

5."Хэсгийн ахлагчийн систем"-ийн аюулгүй байдал, байнгын ажиллагааг хангаж ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (О.Чинзориг)-т;

6.Хэсгийн ахлагчийн системд байршуулах мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг дүүрэг, хороодын Засаг дарга нарт;

7.Хэсгийн ахлагчийн систем ашиглалтын байдлыг “Нийслэлийн шилдэг хороо”, “Шилдэг хэсгийн ахлагчдын баг” шалгаруулах болзолт уралдааны гол шалгуур үзүүлэлтэд тооцох, холбогдох дүрэм, журмыг шинэчлэн батлуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т;

8.Дээрхи үйл ажиллагаанд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Ж.Сандагсүрэн)-д тус тус үүрэг болгов” гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТТБ-2105